



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/38

Мандалговь

“Тэмжин” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 30.4.3, 34.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх “Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний” зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр “Тэмжин” ХХК-ийг сонгон 149,313,780 (нэг зуун дөчин есөн сая гурван зуун арван гурван мянга долоон зуун наян) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан ажлын даалгаврын дагуу хүлээлгэж өгөхийг “Тэмжин” ХХК-ны захирал (Б.Тэмүүжин)-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060155